

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны ... дугаар  
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

## Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 01/287 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Төсөвт байгууллагын батлагдсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага болон орон сууцны айл өрхийн тарифыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын захирал (Б.Алтансүх)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 681 дүгээр тогтоолын хавсралтын 1 дүгээр мөрөнд заасан Төсөвт байгууллагын тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, 2-4 дүгээр мөрөнд заасан Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага болон орон сууцны айл өрхийн тарифыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар /Б.Эрдэнэбулган/-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны  
2024 оны ... дүгээр сарын ....-ний өдрийн  
....дугаар тогтоолын хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД  
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м <sup>3</sup>	2,730.0	
	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/Гж	44,900.0
		тогтмол	Төг/м <sup>3</sup>	1,444.0
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м <sup>3</sup>	2,600.0	
	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/Гж	42,762.0
		тогтмол	Төг/м <sup>3</sup>	1,375.0
3	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "0"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м <sup>2</sup>	1,400.0	
		Төг/Гж	9,075.0	
4	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/хүн	3,533.0	
		Өрх/төг	16,363.0	

--oOo--